



ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

АУДИТЫН СЭДЭВ: “ХҮҮ, ТОРГУУЛИЙН ОРЛОГЫН БҮРДҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТ”-Д
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТ ХИЙСЭН ҮНДЭСЛЭЛ, БҮРЭН ЭРХ: Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, Монгол Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны 2024 оны 05 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2024 оны “Төрийн аудитын байгууллагын 2025 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө батлах тухай” А/108 дугаар тушаал, Ховд аймаг дахь ТАГ-ын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”-г үндэслэн хийж гүйцэтгэлээ.

**ОНОГДУУЛСАН ТОРГУУЛИЙН ОРЛОГЫН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ХЭРЭГЖҮҮЛЭН
АЖИЛЛААГҮЙ БАЙНА.**

АУДИТЫН ТАЙЛАНГ ХҮРГҮҮЛСЭН: Ховд аймгийн Засаг дарга, аймгийн Санхүү төрийн сангийн хэлтэс, Цагдаагийн газар, Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар, Мал эмнэлгийн газар, Статистикийн хэлтэс, Байгаль орчны газар

НЭМЭЛТ МЭДЭЭЛЭЛ, МЭДЭЭЛЛИЙН ЭХ СУРВАЛЖ: Ховд аймаг дахь Төрийн аудитын газар, холбоо барих утас: 70433061

Цахим хуудас: open.audit.mn

Ховд хот

2025.08.26



АУДИТЫН ТАЛААРХ ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ:

Аудитын хураангуй тайлангийн зорилго, зорилтууд, хамарсан хүрээ:

Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт өгч зөвлөмж боловсруулан дүнг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг дарга болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэгдэнэ. Уг зорилгыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэнэ.

Үүнд:

- Хүү, торгуулийн орлогын төлөвлөлт нь хэрэгцээ шаардлагад нийцсэн эсэх;
- Хүү, торгуулийн орлого бүрдүүлэлтийг хууль, журамд нийцүүлэн төвлөрүүлсэн эсэх;
- Хүү, торгуулийн орлогын зарцуулалт үр дүнтэй эсэх;
- Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад тавих хяналт үр дүнтэй хэрэгжсэн эсэх.

Аудитын тайлагналын хэлбэр, зарчим, аудитад хамрагдсан байгууллага:

Аудитад хүү, торгуулийн орлого төлөвлөх, бүрдүүлэх, зарцуулах, хяналт хэрэгжүүлдэг төрийн байгууллагуудын холбогдох чиг үүргийн хэрэгжилт, 2023, 2024 онд хүү, торгуулийн орлогыг бүрдүүлсэн байдал, зарцуулалт, хяналт хэрэгжүүлэх холбоотой тайлан мэдээ, дансны хуулга, бусад нотлох баримт материалыг хамрууллаа.

Торгуулийн орлогын хувьд зөвхөн зөрчлийн тухай хуулийн хүрээнд зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтнуудын торгуулийн ногдуулалтыг авч үзсэн.

Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт:

Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000-д нийцүүлэн боловсруулсан Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандарт, Монгол улсын Ерөнхий аудиторын А/106 дугаар тушаалаар баталсан 2020 оны “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт, түүвэрлэлт хийх, судалгааны арга зүйг ашиглан дүгнэлт, зөвлөмж боловсруулав.



БҮЛЭГ 1. ТОРГУУЛИЙН ОРЛОГЫГ ӨМНӨХ ОНЫ ГҮЙЦЭТГЭЛД ҮНДЭСЛЭН ТӨЛӨВЛӨСӨН Ч ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ШААРДЛАГА БАЙНА

Төсвийн тухай хуулийн дагуу торгуулийн орлогыг төлөвлөсөн байна

1.1.1 Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1¹ дэх хэсэг, 23.3² дах хэсэг, 23.7.2³ дах заалт, 23.9 дэх хэсэгт “Сум, дүүрэг, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны төсвийн татварын бус орлого дараах орлогоос бүрдэнэ”, 23.9.2⁴ дахь заалтуудад торгуулийн орлогыг татварын бус орлогын бүрэлдэхүүн байхаар хуульчилсан байна.

1.1.2 Ховд аймгийн хэмжээнд төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагуудын харилцах дансны үлдэгдэл, нийгмийн даатгалын сангийн дансны чөлөөт үлдэгдэл, хоршоо хөгжүүлэх сангийн зээл, төрийн байгууллагын арилжааны банкин дахь дансны үлдэгдэлд хүүгийн орлого бүрдүүлж байгаа хэдий ч хүүгийн орлогыг төлөвлөөгүй, бусад орлоготой хамтад нь төлөвлөж байна.

1.1.3 Ховд аймгийн татварын бус орлогын 2.3-3.8 хувийг торгуулийн орлогоос бүрдсэн тул өнгөрсөн оны төсвийн гүйцэтгэл, тухайн оны хүлээгдэж буй гүйцэтгэлд үндэслэн уг орлогыг төлөвлөж байна.

1.1.4 Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.5-д “Нийгмийн даатгалын шимтгэл төлөх хугацаа хэтрүүлсэн, цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын хэмжээг бууруулсан болон нуусан орлогод тооцсон алданги, торгууль” нь нийгмийн даатгалын сангийн орлогыг бүрдүүлэх эх үүсвэр байхаар хуульчилсан тул торгуулийн орлогыг сангийн орлогод төлөвлөсөн байна.

Торгуулийн орлогыг өнгөрсөн оны гүйцэтгэлд үндэслэн төлөвлөсөн ч хүүгийн орлогыг төлөвлөөгүй байна

1.2.1 Ховд аймгийн 17 суманд хоршоо хөгжүүлэх сангаас орон нутагт жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч нарт зээл олгож хүүгийн орлого бүрдүүлж байгаа ч тусгайлан хүүгийн орлого төлөвлөхгүй байна.

1.2.2 Орон нутгийн төсвийн торгуулийн орлогын 76-85 хувийг Цагдаагийн газрын торгуулийн орлого эзэлж байгаа бөгөөд үүнээс 48 орчим хувийг цагдаагийн бэлэн бус торгуулийн орлого эзэлж байна.

1.2.3 Аймгийн Цагдаагийн газраас ирүүлсэн судалгаанаас үзэхэд 2023, 2024 онд замын цагдаагийн бэлэн бус торгуулиар 1,183.6 сая төгрөгийн торгууль ногдуулснаас 1,000.6 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлж, өмнөх онуудын торгуулийн орлого 75.3 сая төгрөгийг барагдуулж, 258.3 сая төгрөгийн торгууль барагдаагүй, өмнөх онуудын торгуулийн үлдэгдлийг тодорхойлох боломжгүй байна.

1.2.4 Ховд аймгийн хэмжээнд торгуулийн орлогыг 2023 онд 1,008.4 сая төгрөг, 2024 онд 2,211.7 сая төгрөгөөр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 2023 онд 1,542.3 сая, 2024 онд 2,250.8 сая төгрөг бүрдүүлсэн байна.

1.2.5 Торгуулийн орлого төсөвт төвлөрүүлдэг байгууллагуудын хувьд тайлант онд хэчнээн зөрчил илрүүлэн торгохыг урьдчилан тооцоолох боломжгүй тул торгуулийн орлогыг байгууллагын түвшинд төлөвлөдөггүй, харин аймаг, сумдын төсвийн төслийг

¹ “Төсвийн орлого нь татварын орлого, татварын бус орлогоос бүрдэнэ”;

² “Татварын бус орлого нь төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрийн болон орон нутгийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг, төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр, төрийн болон орон нутгийн өмчийг түрээсэлсний орлого, **торгуулийн орлого**, төсвийн байгууллагын туслах үйл ажиллагааны орлого, Засгийн газрын зээллэг, тусламж болон хууль тогтоомжийн дагуу төсөвт төвлөрүүлэх бусад орлогоос бүрдэнэ”;

³ орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр болон борлуулсны орлого, хүү, торгуулийн орлого;

⁴ Орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр болон борлуулсны орлого, хүү, торгуулийн орлого;



боловсруулахдаа төсөвт төвлөрүүлэх хүү, торгуулийн орлогыг суурь судалгаанд бус өнгөрсөн оны гүйцэтгэлд үндэслэн төлөвлөн баталж байна.

1.2.6 2023, 2024 онуудад торгуулийн орлого аймгийн дүнгээр 2023 онд 53 хувиар, 2024 онд 2 хувиар давж биелсэн бөгөөд Ховд аймгийн хэмжээнд торгуулийн орлого өмнөх оноос өссөн, буурсан нөхцөл байдлын талаар ямар нэг судалгаа шинжилгээ хийгээгүй байна.

Зөрчлийн тухай хуулийн зарим заалтуудыг орон нутагт хэрэгжүүлэхэд хүндрэлтэй, бусад хууль тогтоомжтой нийцээгүй тул нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай байна

1.3.1 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр Боловсролын тухай хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль, Бага дунд боловсролын тухай хуулийг хүчингүй болсонд тооцож мөн өдрөөс Боловсролын ерөнхий хууль батлагдан хэрэгжиж эхэлсэн боловч Зөрчлийн тухай хуулийн 9.1, 9.2 дугаар зүйлд нэмэлт өөрчлөлт ороогүй байна.

1.3.2 Торгууль шийтгэвэр оногдуулах эрх бүхий албан тушаалтнуудын хувьд зөрчлийн хэргийн материал иж бүрдлийг хангахад хугацаа ихээр шаардагдаж, үе шатны ажлууд их хийгддэг тул орон нутагт зөрчил шалган шийдвэрлээгүй, хууль эрх зүйн мэдлэг дутмаг байна.

1.3.3 Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиар нэг зөрчилд олон ЭБАТ торгууль ногдуулахаар байгаа нь ЭБАТ-уудын дунд зөрчил шийдвэрлэгдэхгүй үлдэх, шийдвэрлэхээс зайлсхийх нөхцөл үүсэж болохоор байна. Тухайлбал: мал үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээний хяналтын улсын байцаагч, цагдаа, авто тээврийн улсын байцаагч, газар, геодези, зураг зүйн хяналтын улсын байцаагч, байгаль орчны хяналтын улсын байцаагч гэх мэт

1.3.4 Орон нутгийн онцлог нөхцөл байдал, боловсон хүчин дутагдал, төсвийн хүрэлцээгүй байдал зэрэг нөлөөллөөс шалтгаалан Зөрчлийн тухай хуульд заасан торгууль шийтгэвэр оногдуулах, зарим зүйл заалтыг хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байна. Үүнд:

- Мал үржүүлэг технологийн үйлчилгээний ажлыг мэргэжлийн ажил үйлчилгээний байгууллагаар гүйцэтгүүлж санхүүжилтийг хуулийн дагуу улсын болон орон нутгийн төсөвт тусгуулан засаг даргатай гэрээ байгуулан гүйцэтгэх байтал орон нутагт мэргэжлийн ААН-ийн тоо цөөн, үйл ажиллагаа тогтмолжоогүй, санхүүжилт дутагдалтайгаас нийт малын багахан хэсэгт үзлэг, ангилалт, ялган тэмдэгжүүлэлт хийдэг тул Малын генетикийн тухай хуулийн заалтын хэрэгжилт хангагдаагүй зөрчилд торгууль ноогдуулдаггүй,
- Орон нутагт ургамал хамгааллын бодисын хэрэглээг тодорхойлох боломжгүй, бордоо болон ургамал хамгааллын бодис худалдан борлуулдаг тусгай зөвшөөрөлтэй ААНБ байхгүй учраас гэрээт болон хувь хүнээс тариалан эрхлэгчид ургамал хамгааллын бодис худалдан авдаг, ургамал хамгааллын бодисын агууламж, чанар стандартыг лабораторигүй тул тодорхойлох боломжгүй,
- Эрүүл мэндийн сайд, Байгаль орчин уур амьсгалын өөрчлөлтийн яамны сайд, ХХААХҮС-ын хамтарсан тушаалаар батлагдсан жагсаалтад орсон бүтээгдэхүүнийг нийлүүлж байгаа эсэхэд хяналтыг бүрэн хэрэгжүүлэх боломжгүй тул торгууль ноогдуулдаггүй,
- Тариалангийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулахад тариалангийн үйлдвэр эрхлэгч тариалангийн газрыг ашиглахгүй өнжөөх, тариалангийн талбайн ойролцоо 500м зайд мал бэлчээх, оторлох зэрэг асуудалтай холбоотой зөрчил голчлон гардаг боловч эрх бүхий албан тушаалтан аймгийн хэмжээнд 1 ажиллаж байгаа нь хүрэлцдэггүй,

1.3.5 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль зөрчвөл Зөрчлийн тухай хуулийн 10.15 дугаар зүйлд заасны дагуу торгож, арга хэмжээ тооцохоос Хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч нь зөвхөн Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.52 дахь заалтын дагуу Зөрчлийн тухай хуулийн 10.15 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасан зөрчлийг л зөвхөн шалган шийдвэрлэхээр, бусад 4 зөрчлийг Хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагч шийдвэрлэхээр зүйлчилж өгсөн нь Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2 дахь хэсэгт заасан Хөдөлмөрийн хяналтын улсын байцаагчийн эрхтэй зөрчилдөж байна.



1.3.6 Торгуулийн хэмжээг цаашид үүсэх үр нөлөөг тооцон тогтоох шаардлагатай байна. Тухайлбал:

- Гал түймрийн улмаас орон гэргүй, эд хөрөнгөөрөө хохирсон байхад Зөрчлийн тухай хуулиар торгуулийн арга хэмжээ авч байгаа нь хөрөнгөгүй болсон иргэнд нэмэлт санхүүгийн дарамт үүсгэх үр нөлөөтэй,
- Боловсролын салбарын хяналтаар Зөрчлийн тухай хуулийн 9.1 дүгээр зүйлийн 1-д “Суралцагчид сэтгэл санааны дарамт үзүүлсэн, эсхүл мөнгө өгөх, ном, бүтээгдэхүүн худалдаж авахыг тулгасан, эсхүл хуульд заагаагүй төлбөр, хураамж авсан бол хүнийг 20 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг 200 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” гэсэн заалт нь бодит байдалд торгуулиа төлөөд тухайн зөрчлийг давтан гаргах эрсдэлтэй учраас үйлдсэн зөрчилд ногдох торгуулийн хэмжээ бага,
- Зөрчлийн тухай хуулийн 13.9⁵-р зүйлийн 4-д заасны дагуу малчид дураараа эм хэрэглэх тохиолдолд торгож байгаа нь үйлдсэн зөрчлөөс үүсэх үр дагавартай харьцуулахад бага,
- Зөрчлийн тухай хуулийн 7.1 дүгээр зүйлийн 2-д “Байгаль орчны менежментийн төлөвлөгөөгүй ажилласан, эсхүл уг төлөвлөгөөг хэрэгжүүлээгүй, биелэлтийг тогтоосон хугацаанд гаргаж, холбогдох газарт тайлагнаагүй бол хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” гэж заасан нь үр дагавартай харьцуулахад торгуулийн хэмжээ бага байна.

1.3.7 Зөрчлийн тухай хуулийн 2.3 дугаар зүйлийн 4-д “Төрийн албан хаагчийн хуулиар хүлээсэн албаны чиг үүргээ хэрэгжүүлсэн үйлдэл, эс үйлдэхүй нь энэ хуульд заасан зөрчлийн шинжтэй бол түүнд холбогдох хууль тогтоомжид заасан сахилгын шийтгэл хүлээлгэнэ. Төрийн албан хаагчийн албаны чиг үүргээ хэрэгжүүлсэн үйлдэл, эс үйлдэхүйтэй холбоогүй зөрчилд энэ хуульд заасан нийтлэг журмаар шийтгэл оногдуулж, албадлагын арга хэмжээ хэрэглэнэ” гэсэн заалтаар зөвхөн сахилгын арга хэмжээ авч байгаа нь хууль хэрэглээ бүх нийтэд адил тэгш үйлчлэхгүй байна.

1.3.8 Орон нутагт хяналт шалгалтын чиг үүрэг хэрэгжүүлэх улсын байцаагч нарын эрх олгохдоо Засгийн газрын тогтоолоор баталсан “Хяналтын улсын байцаагчийн эрх олгох, цуцлах журам” байгаа боловч зарим салбар өөр шалгуур үзүүлэлтээр олгож байгаа нь тэгш байдлыг хангахгүй байна.

1.3.9 Зөрчлийн тухай хуулийн 2.4 дүгээр зүйлийн 1.12⁶-д оногдуулсан торгуулийг биелүүлээгүй бол албадан гүйцэтгүүлэхээр шүүхэд хандахаар зохицуулсан бөгөөд хууль бусаар, шүүхийн шийдвэргүйгээр иргэний өмчийн халдашгүй байдалд халдсан талаар гомдол мэдээлэл бүртгэгдээгүй байна.

1.3.10 Зөрчлийн улмаас үүсэх үр нөлөө, онцлог шинж чанарыг харгалзан нарийвчлан судалгаа хийж Зөрчлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлага байна.

БҮЛЭГ.2 ОНОГДУУЛСАН ТОРГУУЛИЙН ОРЛОГЫН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙГЭЭС 355.6 САЯ ТӨГРӨГИЙГ ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛЭЭГҮЙ БАЙНА.

Оногдуулсан торгуулийн орлогын 88.7 хувь буюу 2,190.4 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлснээс улсын төсөвт 12.5 хувийг буюу 274.0 сая төгрөг төвлөрүүлсэн нь төсвийн тухай хуультай нийцэхгүй байна

2.1.1 Ховд аймгийн хэмжээнд төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын харилцах дансны үлдэгдэл, нийгмийн даатгалын сангийн дансны чөлөөт үлдэгдэл, хоршоо хөгжүүлэх сангийн зээл зэргээс хүүгийн орлого бүрдэж байна.

2.1.2 2023 онд 187.4 сая, 2024 онд 146.1 сая, нийт 333.5 сая төгрөгийн хүүгийн орлого бүрдүүлж, 2023- 2024 онд хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн хүүд 209.8 сая төгрөг,

⁵ “Малчин, амьтан маллагч, мал, амьтан өмчлөгч нь малын эмийн улсын бүртгэлд бүртгэгдээгүй эм хэрэглэсэн бол хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр”

⁶ зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээд шийтгэл оногдуулсан шийдвэрийг тогтоосон хугацаанд биелүүлээгүй, зөрчлийн үр дагаврыг арилгахтай холбоотой зардлыг нөхөн төлөөгүй бол албадан гүйцэтгүүлэхээр шүүхэд хүсэлт гаргах;



нийгмийн даатгалын сангийн харилцах дансны чөлөөт үлдэгдэлд тооцсон хүү 116.1 сая төгрөг, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын харилцах дансны үлдэгдэлд тооцсон хүү 6.6 сая, төрийн байгууллагын арилжааны банкин дахь дансны үлдэгдэлд тооцсон хүү 1.0 сая төгрөг, нийт 333.5 сая төгрөгийн орлого бүрдүүлжээ.

2.1.3 Ховд аймгийн хэмжээнд 29 байгууллагад 280 улсын байцаагч ажиллаж зөрчлийн хэрэг шалган шийдвэрлэж байна.

2.1.4 Дээрх эрх бүхий албан тушаалтнууд Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн дагуу 2023 онд 34168 зөрчилд 1,390.5 сая төгрөг, 2024 онд 25746 зөрчилд 1,079.9 сая төгрөгийн торгуулийг оногдуулжээ.

2.1.5 2023 онд 17 байгууллагын ЭБАТ-ууд 34,169 зөрчлийг шийдвэрлэж, 12 байгууллага ямар нэг зөрчил шалган шийдвэрлээгүй, 2024 онд 21 байгууллагын ЭБАТ-ууд 25,746 зөрчлийг шийдвэрлэж, 8 байгууллага ямар нэг зөрчил шалган шийдвэрлээгүй байна.

2.1.6 2023 онд 1,390.5 сая төгрөгийн торгууль оногдуулснаас 1,105.9 сая төгрөгийн орлогыг, 2024 онд нийт 1,079.9 сая төгрөгийн торгууль оногдуулснаас 1,084.5 сая төгрөгийн нийт 2,190.4 сая төгрөгийг буюу 88.7 хувийг төсөвт төвлөрүүлжээ. Үүнээс 12.5 хувийг улсын төсөвт, 87.4 хувийг орон нутгийн төсөвт, 0.1 хувийг тухайн байгууллагын төсөвт төвлөрүүлсэн.

2.1.7 2023 онд нийт 44 зөрчилтэй холбоотой 284.6 сая, 2024 онд нийт 101 зөрчилтэй холбоотой 71.0 сая, нийт 355.6 сая төгрөгийн торгуулийг барагдуулаагүй байна. Үүнээс 326.2 сая төгрөг буюу 86.6 хувийг цагдаагийн газрын торгуулийн үлдэгдэл эзэлж байна.

2.1.8 2023 онд 5, 2024 онд 5 байгууллагын ЭБАТ-уудын оногдуулсан торгуулийн үлдэгдлийг барагдуулаагүй байна.

2.1.9 Улсын Ерөнхий Прокурор, Хууль зүй дотоод хэргийн сайдын хамтарсан 2024 оны А/41, А/71 тоот хамтарсан тушаалаар баталсан "Эрх бүхий албан тушаалтнаас торгох шийтгэлийг нэмэгдүүлж тооцох хугацаа, аргачлал"-ын дагуу торгуулийг хугацаандаа төлөөгүй тохиолдолд Зөрчлийн тухай хуулийн 3.5 дугаар зүйлийн 4⁷-д (2024 оны 4 дүгээр сараас) заасны дагуу нэмэгдүүлэн тооцоогүй байна.

✓ Аймгийн Цагдаагийн газар нь 2024 онд 62 иргэний 32,200.0 мянган төгрөгийн торгууль шийтгэврийн үлдэгдлээс 16,100.0 мянган төгрөгийг нэмэгдүүлэн тооцоогүй;

✓ Аймгийн Хүүхэд гэр бүлийн хөгжил хамгааллын газар 3 зөрчилтэй холбоотой 1,100.0 мянган төгрөгийн торгууль шийтгэврийн үлдэгдлээс 550.0 мянган төгрөгийг нэмэгдүүлэн тооцоогүй;

✓ ХХААГ 3 зөрчилтэй холбоотой 3,000.0 мянган төгрөгийн торгууль шийтгэврийн үлдэгдэлд 1,500.0 мянган төгрөгийг нэмэгдүүлэн тооцоогүй;

✓ Байгаль орчны газар нь 2 зөрчилтэй холбоотой 6,000.0 мянган төгрөгийн торгууль шийтгэврийн үлдэгдэлд 3,000.0 мянган төгрөгийг нэмэгдүүлэн тооцоогүй;

2.1.10 Хугацаа хэтэрсэн торгуулийн үлдэгдлийг барагдуулах чиглэлээр эрх бүхий албан тушаалтнууд холбогдох арга хэмжээ авч ажиллаагүй байна.

✓ Аймгийн Хүүхэд, гэр бүл, хүүхэд хамгааллын газар нь хугацаа хэтэрсэн 2023 онд 7 иргэнд оногдуулсан 2,200.0 мянган төгрөг, 2024 онд 13 иргэнд оногдуулсан 6,100.0 мянган төгрөгийн торгуулийн үлдэгдэлтэй байгаагаас 2024 оны 10 иргэнд оногдуулсан 5,000.0 мянган төгрөгийн шийтгэврийг албадан гүйцэтгүүлэхээр шүүхэд хүсэлт гаргасан боловч шүүх албадан гүйцэтгүүлэх хүсэлтийг нь

⁷ Эрх бүхий албан тушаалтнаас оногдуулсан торгох шийтгэлийг энэ хуульд заасан хугацаанд биелүүлээгүй бол шийтгэлийн хэмжээг 50 хүртэл хувиар нэмэгдүүлнэ.



хэрэгсэхгүй болгосон байна. Журмын дагуу барагдуулаагүй торгуулийн үлдэгдлийг нэмэгдүүлэн тооцож, нийтийн тустай ажил хийлгэхээр саналыг шүүхийн байгууллагад хүргүүлээгүй;

✓ Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын эрх бүхий албан тушаалтан 2023 онд 1 хуулийн этгээдтэй холбоотой 1,500.0 мянган төгрөгийн торгууль оногдуулсан ч торгуулийг төлүүлэхээр шүүхэд хандаагүй;

✓ Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар 2024 онд 1 зөрчилтэй холбоотой 500.0 мянган төгрөгийн торгуулийн үлдэгдлийг төлүүлэхээр шүүхэд хандаагүй;

✓ Байгаль орчны газрын эрх бүхий албан тушаалтан 2023 онд онд 1 иргэнтэй холбоотой 100.0 мянган төгрөгийн, 2024 онд 2 хуулийн этгээдтэй холбоотой 6,000.0 мянган төгрөгийн, нийт 6,100.0 мянган төгрөгийн торгуулийг төлүүлэхээр шүүхэд хандаагүй;

✓ Цагдаагийн газар нь 2023 онд 280,843.4 мянган төгрөг, 2024 онд 45,400 мянган төгрөг нийт 326,243.4 мянган төгрөгийн торгуулийн үлдэгдлээс 2023 оны 1 иргэнтэй холбоотой 400.0 мянган төгрөгийн, 2024 оны 4 иргэнтэй холбоотой 500.0 мянган төгрөгийн торгуулийг аймгийн шүүхийн байгууллагад шилжүүлж, бусад торгуулийн үлдэгдлийг барагдуулаагүй;

2.1.11 Эрх бүхий албан тушаалтнуудын шалган шийдвэрлэж оногдуулсан хугацаандаа төлөгдөөгүй торгуулийн үлдэгдэлд шүүхийн шийдвэрийн дагуу 2023 онд 130 гүйцэтгэх баримт бичигт 47.8 сая, 2024 онд 125 гүйцэтгэх баримт бичигт 69.7 сая төгрөгийн торгуулийг албадан барагдуулсан байна.

2.1.12 2024 онд “Уул уурхайн нөхөн сэргээлтийн сангийн үйл ажиллагаа, үр дүн, үр нөлөө” сэдэвт нийцлийн аудитаар хайгуулын тусгай зөвшөөрөлтэй, Ховдын Тулга ХХК (2023–2025 онд), Соёмбот Шүтээн Хайрхан ХХК (2025 онд), Тунгалаг буянт ХХК байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлуулаагүйгээр үйл ажиллагаа явуулсан, ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Жаргалант рашаант” ХХК (2020–2025 онд), ОДЦЭ ХХК (2020–2025 онд) байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлуулаагүй байхад үйл ажиллагаа явуулсаар байгаа зөрчилд торгууль оногдуулаагүй зэрэг зөрчил илэрсэн тул Байгаль орчны газарт зөрчлийг шийдвэрлэх албан шаардлага хүргүүлсэн байна.

2.1.13 Аймаг, Нийслэл, Сум, Дүүргийн ИТХ-ын сонгуульд оролцсон нам, эвсэл, нэр дэвшигчийн зардлын тайланг хянаж, олон нийтэд мэдээлэх нийцлийн аудитаар илэрсэн зөрчилд аймгийн Татварын газар болон ЗДТГ-аас зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг явуулж байна.

2.1.14 Орон сууцны 0 болон 1 давхрыг үйлчилгээний зориулалтаар өөрчилж, орон сууцны хана нураах, хаалга гаргах, гадна хийцийг өөрчлөх зэрэг зөрчлүүдэд аймгийн төвд нийтлэг гарч байхад зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулаагүй байна.

2.1.15 2023, 2024 оны статистик мэдээг хугацаанаас хоцроож ирүүлсэн 21 зөрчилд статистикийн улсын байцаагч зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулаагүй байна.

2.1.16 Барилга эхлэх зөвшөөрөл авалгүйгээр барилгын ажил явуулах, газрын ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөө зөрчиж барилга байгууламж барьсан зөрчил аймгийн хэмжээнд гарсаар байгаа ч аймгийн ГХБХБГ-аас хувийн хэвшлийн хөрөнгөөр баригдаж буй 10 барилга байгууламж, 3 үйлчилгээний төвд зөрчлийн хэрэг нээн шалган шийдвэрлээгүй, хяналт хэрэгжүүлээгүй байна.

2.1.17 Орон нутгийн төсвийн орлогод торгуулийн орлогыг төвлөрүүлэхээр Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.7.2-д хуульчилсан байхад торгуулийн орлогын дансанд улсын тэмдэгтийн хураамж, улсын тэмдэгтийн хураамжийн дансанд торгуулийн орлогыг төвлөрүүлсэн байна. Үүнд:

✓ Аймгийн Цагдаагийн газрын хүү торгуулийн орлогын дансанд улсын бүртгэлийн хураамжийн 912.5 мянган төгрөгийг төвлөрүүлсэн;



- ✓ Аймгийн Онцгой байдлын газар нь улсын бүртгэлийн тэмдэгтийн хураамжийн дансанд торгуулийн орлого 600.0 мянган төгрөгийг төвлөрүүлсэн;

2.1.18 ХХАА-н газар аймгийн хэмжээнд 17 эрх бүхий ажилтан буюу улсын байцаагч ажиллах ёстой байтал өнөөдрийн байдлаар хөдөөгийн 5 сум, аймгийн ХХААГ-т 1 нийтдээ 6 улсын байцаагчтай ажиллаж байгаа нь зөрчлийг илрүүлэх, гарсан зөрчлийг шалган шийдвэрлэх үйл ажиллагаанд нөлөөлж байна.

Хүү, торгуулийн орлогыг хуулийн дагуу хуваарилсан байна

2.2.1 Торгуулийн орлогыг хуваарилахдаа Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46.1, Автозамын тухай хуулийн 24 дүгээр зүйлд заасан арга хэмжээнд болон орон нутгийн төсвийн суурь зарлагыг санхүүжүүлэхээр төсөвт тусган баталсан байна.

2.2.2 2023 онд авто замын замын санд 1,642.2 сая төгрөг, 2024 онд 1,971.8 сая төгрөгийг Цагдаагийн газрын торгуулийн орлого, авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын орлогоос, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 2023 онд 215.8 сая төгрөг, 2024 онд 473.1 сая төгрөгийг Цагдаагийн газрын торгуулийн орлогоос тус тус хуваарилсан байна.

2.2.3 Төсвийн хуваарилалтыг хийхдээ Цагдаагийн газрын торгуулийн орлогыг гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 40 хувь, Авто замын сангийн засвар арчлалтад 60 хувийг тус тус хуваарилж, сумдын авто замын засвар үйлчилгээний зардлыг орон нутгийн авто замын хураамжаас санхүүжүүлэхээр 2023 онд 277.1 сая, 2024 онд 200.8 сая төгрөгийг хуваарилсан байна.

2.2.4 2023 онд 7 байгууллагын ЭБАТ-ын 119.5 сая, 2024 онд 11 байгууллагын ЭБАТ-ын 154.5 сая төгрөгийн торгуулийн орлогыг улсын төсвийн дансанд төвлөрүүлсэн байна.

2.2.5 2023 онд 11 байгууллагын ЭБАТ-ын 87.9 сая, 2024 онд 14 байгууллагын ЭБАТ-ын 74.7 сая төгрөгийн торгуулийн орлогыг орон нутгийн төсвийн дансанд төвлөрүүлж, орон нутгийн төсвийн суурь зарлагыг санхүүжүүлэхээр хуваарилсан байна.

2.2.6 Нийгмийн даатгалын газар нь 2023-2024 онд 116,1 сая төгрөгийн хүүгийн орлого, 4.4 сая төгрөгийн торгуулийн орлого бүрдүүлж, 2.0 сая төгрөгийн торгуулийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлж, бусад хүү, торгуулийн орлогыг Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 12 зүйлийн 11.1⁸-д заасны дагуу нийгмийн даатгалын санд хуваарилсан байна.

2.2.7 Хоршоо хөгжүүлэх сан нь 2023 онд 128.2 сая төгрөг, 2024 онд 81.6 сая төгрөгийн орлого бүрдүүлж, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А/361 дүгээр тушаалын хавсралтаар баталсан “хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 21⁹-д заасны дагуу Хоршоо хөгжүүлэх сангийн зээл, үйл ажиллагааны зардалд зарцуулжээ.

2.2.8 Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой байгууллагууд 2023 онд 2.9 сая, 2024 онд 3.7 сая төгрөгийн хүүгийн орлогыг үйл ажиллагааны зардалд зарцуулсан байна.

2.2.9 Төрийн байгууллагын 2023 онд 0.2 сая, 2024 онд 0.8 сая төгрөгийн хүүгийн орлогыг дээд байгууллагын дансанд төвлөрүүлсэн байна.

2.2.10 Торгуулийн орлогын биелэлтийг эрх бүхий албан тушаалтны ажлын үр дүнд буюу ажил дүгнэх үзүүлэлтэд харгалзан үзэх боломжгүй байна.

2.2.11 Цаашид торгуулийн авлагыг төсөвт төвлөрүүлэх, нэмэгдүүлэн тооцох, торгуулийн орлогын биелэлтэд тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

⁸ 11.1. Нийгмийн даатгалын сангийн орлого дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

11.1.5. нийгмийн даатгалын шимтгэл төлөх хугацаа хэтрүүлсэн, цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын хэмжээг бууруулсан болон нуусан орлогод тооцсон алданги, торгууль;

11.1.7. хуульд заасан бусад эх үүсвэр.

⁹ 2.1. Сангийн хөрөнгийг дараах эх үүсвэрээс бүрдүүлнэ:

2.1.3. сум хөгжүүлэх сангаас иргэн, аж ахуйн нэгжид олгосон зээлийн эргэн төлөлтийн төлбөр;

2.1.4. сангаас аж ахуйн нэгжид олгосон зээлийн эргэн төлөлтийн төлбөр;



БҮЛЭГ 3. ТОРГУУЛИЙН ОРЛОГЫГ ИРГЭДЭД ИЛ ТОД МЭДЭЭЛСЭН Ч ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖИЛД ХАМААРАЛГҮЙ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХӨРӨНГӨ ЗАРЦУУЛСАН БАЙНА

Торгуулийн орлогоос шаардлагатай хөрөнгө оруулалтын ажлуудыг санхүүжүүлэн үр нөлөөтэй хэрэгжиж байгаа ч гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардалд хамаарахгүй 137.4 сая төгрөгийг зарцуулсан байна

3.1.1 Аймгийн замын сангийн хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээнд аймгийн ИТХ-ын 2023 оны 12/02 тогтоолоор 15 хөтөлбөр арга хэмжээнд 1,642.2 сая төгрөг баталж, 13 хөтөлбөр арга хэмжээнд 1,392.5 сая төгрөг, 2024 оны 18/03 дугаар тогтоолоор 13 хөтөлбөр арга хэмжээнд 1,971.7 сая төгрөг баталж, 11 хөтөлбөр арга хэмжээнд 1,740.0 сая төгрөгийг зарцуулсан байна.

3.1.2 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардалд 2023 онд 100.0 сая төгрөг, 2024 онд 274.4 сая төгрөгийн зарцуулжээ.

3.1.3 Цагдаагийн газрын торгуулийн орлогыг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа, авто замын сангийн үйл ажиллагаанд хуулийн дагуу хуваарилалт хийж байгаа ч гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөл нь байгууллагын үйл ажиллагааны зардалд буюу зориулалтын дагуу зарцуулаагүй байна.

✓ Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөл нь 2023 онд 32.3 сая төгрөг, 2024 онд 101.8 сая төгрөгийг байгууллагын үйл ажиллагааны зардалд зарцуулсан байна.

3.1.4 Авто замын сангийн хөрөнгө оруулалтаар 2023 онд 1,392.5 сая төгрөг, 2024 онд 1,740.0 сая төгрөгийг зарцуулсан байна.

3.1.5 Гэмт хэргийн тоо 2024 оны байдлаар 2023 оны мөн үетэй харьцуулж үзвэл хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 10.3-20 хувиар өссөн бол эд хөрөнгөтэй /мал болон хөрөнгө өмчлөхтэй/ холбоотой гэмт хэргүүд 3.3-53.7 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

3.1.6 Торгуулийн орлогоос замын сангийн бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ хэрэгжсэнээр ард иргэдийн амьдралд ачаа, тээврийн зардал буурах, хөдөө, алслагдсан нутгийн бүтээгдэхүүн зах зээлд хүрэх боломж сайжрах, осол, аюулгүй байдлын түвшин буурах, хөдөө орон нутагт амьдрах, бизнес эрхлэх боломж бүрдэх зэрэг нийгэм, эдийн засгийн шууд нөлөө үзүүлж байна.

Торгуулийн орлогын зарцуулалтыг шилэн дансны нэгдсэн системд ил тод мэдээлж байна

3.2.1 Төсвийн ерөнхийлөн захирагчийн шилэн дансны системд татварын болон татварын бус орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг жил бүр нээлттэй мэдээлсэн байна.

3.2.2 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зарцуулалт, салбар зөвлөлийн үйл ажиллагааны талаар мэдээллийг сошиал хуудас тараах материал, орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд хүргэж байна.

3.2.3 Аймаг болон сумдын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас санхүүжүүлсэн зөвлөлд хуваарилсан хөрөнгийн зарцуулалтыг аймгийн болон сумдын ИТХ-ын шилэн дансны “Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл-хөтөлбөр, зориулалт” хэсэгт бүрэн мэдээлсэн байна.



БҮЛЭГ 4. ТОРГУУЛИЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН БҮРТГЭЛИЙН СИСТЕМГҮЙГЭЭС ОНОГДУУЛСАН ТОРГУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ БҮРЭН ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙ БАЙНА

Торгуулийн орлого бүрдүүлэгч зарим байгууллагууд дотооддоо ашигладаг мэдээллийн сантай ч нэгдсэн мэдээллийн сан байхгүйгээс торгуулийн шийдвэрлэлтийг хянах, дүн шинжилгээ хийхэд хүндрэлтэй байна

4.1.1 Хүү, торгуулийн орлого төвлөрүүлэгч зарим байгууллагуудын хувьд дотооддоо ашигладаг мэдээллийн системтэй, салбарын хуулиудад мэдээллийн систем ашиглах чиглэлийг баримтлах талаар дараах байдлаар тусгажээ. Үүнд:

- Гаалийн тухай хуулийн 13 дугар зүйлийн 13.3¹⁰ дахь хэсэгт гаалийн үйл ажиллагааны мэдээллийн санг ашиглахаар;
- Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1¹¹-т мэдээллийн санг ашиглахаар, мэдээллийн санд байгаль орчны холбогдолтой гэмт хэрэг, зөрчлийн мэдээллээс бүрдэнэ гэж тусгасан байна.
- Татварын ерөнхий хуулийн 32 дугаар зүйлийн 32.1¹² дэх хэсэгт мэдээллийн сантай байхаар
- Цагдаагийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1¹³ дэх хэсэгт мэдээллийн санг ашиглахаар
- Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2¹⁴ дахь хэсэгт улсын бүртгэлийн мэдээллийн санг ашиглахаар

4.1.2 Гэвч төрийн байгууллагуудын хоорондын нэгдсэн мэдээллийн сан байхгүйгээс гарч буй зөрчил урьд онуудын торгуулийн үлдэгдэл, торгууль оногдуулалт, шийдвэрлэлт зэрэг харьцуулсан үзүүлэлт гаргах, судалгаа шинжилгээ хийх боломжгүй байна.

4.1.3 Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн портал Е-Монголиа систем, Ebarimt.mn цахим системүүдийг ашиглан зарим байгууллагын торгуулийн мэдээллийг лавлаж, төлөлт хийх болсон нь үр дүнтэй байна.

4.1.4 Цагдаагийн газрын тухайд 2023, 2024 онд бэлэн бус хэлбэрээр оногдуулсан торгуулийн мэдээллийг дараах системүүдээр дамжуулан лавлаж, төлөх боломжтой болсон байна. Үүнд: Smartcar.mn цахим хуудас, Е-Монголиа, 102 Police аппликейшн, “Гэрэгэ киоск” машинаар дамжуулж биеэр төлөх, Ebarimt.mn

Хуулийн дагуу прокурорын газраас эрх бүхий албан тушаалтнуудын зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд хяналт тавьж байгаа ч эрх бүхий албан тушаалтан нь зөрчлийг прокурорын нэгдсэн бүртгэлд бүртгүүлээгүй байна

4.2.1 Торгуулийн хуудасны тооцоог орон нутгаас болон харьяалах дээд байгууллагаас авч хэрэглэдэг боловч үнэт цаасны тооцоог хянаж баталгаажуулаагүй, санхүү бүртгэлд тусгаагүй нь хяналтын тогтолцоо, дүрэм журам харьцангуй сул байгааг харуулж байна.

4.2.2 Торгууль оногдуулж буй эрх бүхий албан тушаалтнууд орон нутгийн торгуулийн орлогын данснуудын орлого, зарлагыг хянаж тооцоо хийгээгүйгээс оногдуулсан торгуулийн үлдэгдэл барагдсан эсэх, торгуулийн орлогын дансанд төвлөрч байгаа эсэх талаар

¹⁰ “Гаалийн удирдах төв байгууллага нь энэ хуулийн 13.1-д заасан мэдээллийг гаргах зорилгоор гаалийн мэдүүлэгт үндэслэсэн гаалийн мэдээллийн санг бүрдүүлж, хөтөлнө”

¹¹ “Мэдээллийн санг цахим хэлбэрээр бүрдүүлнэ”

¹² “Татварын алба татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сантай байна. Татварын алба чиг үүргээ хэрэгжүүлэх, мэдээлэл солилцох зорилгоор мэдээллийн систем, технологийг ашиглах бөгөөд тэдгээрийн нууцлал, найдвартай байдлыг бүрэн хангаж ажиллана”

¹³ “Цагдаагийн байгууллага бүртгэл хөтөлж, мэдээллийн сүлжээ, сан үүсгэн үйл ажиллагаандаа ашиглана”

¹⁴ хэсэгт “Улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сан нь энэ хуулийн 6, 7, 8 дугаар зүйлд заасан улсын бүртгэлийн эх нотлох баримт бичгийн архив, цахим мэдээллийн сангаас бүрдэнэ”



мэдээлэлгүй байгаа нь Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7.5 дугаар зүйлийн 1¹⁵ дэх хэсэгт заасныг хэрэгжүүлээгүй байна.

4.2.3 Орон нутгийн төсвийн торгуулийн орлого бүрдүүлэгч байгууллагууд нь ихэвчлэн босоо тогтолцоотой байгаагаас тэдний ажлыг дүгнэх, үйл ажиллагаанд нь хяналт тавих, хариуцлага тооцох механизм тодорхойгүй байна.

4.2.4 Торгууль, шийтгэлийн бүртгэл, шийдвэрлэлт, үлдэгдэлд байгууллагуудын удирдлагын хяналт хэрэгжүүлээгүй, мэдээллийн нэгдсэн тогтолцоо бүрдээгүй нь торгуулийн орлогын бүрдүүлэлтэд тавих дотоод хяналт сул байгааг илтгэж байна.

4.2.5 Прокурорын газрын хяналтын прокурор Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 2.2 дугаар зүйлийн 1-д заасны дагуу ЭБАТ-ын зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд хяналт тавьж, 2023 онд 84 зөрчлийг хүчингүй болгож, 5 зөрчилд хуулийн дагуу өөрчлөлт оруулсан, 2024 онд 635 зөрчлийг хүчингүй болгож, 115 зөрчилд хуулийн дагуу өөрчлөлт оруулсан байна.

4.2.6 Торгуулийн хуудас бичсэн боловч прокурорт бүртгүүлээгүй байгаа нь торгууль оногдуулах ЭБАТ хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй, түүнд байгууллагын зүгээс тавих дотоод хяналт хэрэгжүүлээгүй байна.

✓ Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын ЭБАТ 2024 онд 1 зөрчил шалган шийдвэрлэхдээ прокурорт бүртгүүлээгүй;

✓ Дуут сумын байгаль орчны хяналтын улсын байцаагч 2023 онд 1 зөрчил, 2024 онд 1 зөрчил шалган шийдвэрлэхдээ прокурорт бүртгүүлээгүй;

4.2.7 Тайлант хугацаанд хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт зарцуулалтад иргэн, төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, зөвлөлөөс хөндлөнгийн хяналт хэрэгжүүлээгүй байна.

4.2.8 Улсын хэмжээнд төрийн байгууллагуудын торгуулийн орлогын мэдээллийн системийн цогц байдлыг бүрэн хангаж, орлогын бүрдүүлэлтэд цахим технологийн дэвшлийг үр дүнтэй хэрэгжүүлэн, зөрчлийг бууруулахад дүн шинжилгээ хийж ажиллах нь чухал байна.

ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

1. Торгуулийн орлогыг Төсвийн тухай хуульд нийцүүлэн торгуулийн орлогыг өнгөрсөн оны гүйцэтгэлд үндэслэн төлөвлөсөн байна.
2. Зөрчлийн тухай хуулийн зарим заалтуудыг орон нутагт хэрэгжүүлэхэд хүндрэлтэй, бусад хууль тогтоомжтой нийцээгүй тул нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай байна.
3. Эрх бүхий албан тушаалтнууд нь зөрчил шалган шийдвэрлэж торгууль оногдуулахад бүрдүүлэх баримт материал, цаг хугацаа их шаардагддаг, хууль эрх зүйн мэдлэг дутмаг байдаг зэргээс шалтгаалан Зөрчлийн тухай хуульд заасан зарим зөрчилд торгууль оногдуулаагүй байна.
4. Оногдуулсан торгуулийн орлогын хэрэгжилтэд хяналт тавиагүйгээс торгуулийн орлогын 14.4 хувь буюу 355.6 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлээгүй байна.
5. Төсвийн тухай хуульд заасны дагуу торгуулийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлээгүй, улсын төсөвт төвлөрүүлснээс 274.0 сая төгрөгийн орлого орон нутгийн төсөвт ороогүй байна.
6. 2023, 2024 онуудад нийт 145 зөрчилтэй холбоотой 355.6 сая төгрөгийн торгуулийг барагдуулаагүй байгаагаас 326.2 сая төгрөг буюу 86.6 хувийг цагдаагийн газрын торгуулийн үлдэгдэл эзэлж байна.
7. Хүү, торгуулиас бүрдсэн орлогыг хуулийн дагуу хуваарилсан байна.
8. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас 2023, 2024 онуудад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга

¹⁵ “Эрх бүхий албан тушаалтан шийтгэл оногдуулсан, албадлагын арга хэмжээ авсан шийдвэрийнхээ биелэлтийг хариуцна”



хэмжээнээс бусад үйл ажиллагаанд хөрөнгө зарцуулсан байна.

9. Хүү, торгуулийн орлогын зарцуулалтыг шилэн дансны нэгдсэн системд ил тод мэдээлж байна.
10. Торгуулийн нэгдсэн бүртгэл, мэдээллийн системгүйгээс оногдуулсан торгуулийн хэрэгжилтэд хяналт хэрэгжүүлээгүй байна.
11. Хуулийн дагуу прокурорын газраас эрх бүхий албан тушаалтнуудын зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд хяналт тавьж байгаа ч эрх бүхий албан тушаалтан нь прокурорын нэгдсэн бүртгэлд бүртгүүлээгүй байна.

Аудитаар нийт 378.6 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 367.2 сая төгрөгийн 14 зөрчилд 8 албан шаардлага, 11.4 сая төгрөгийн 7 зөрчилд 7 зөвлөмж өгөв.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ:

Гүйцэтгэлийн аудитын дүн дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

Аймгийн Засаг дарга М.Амарсанаад

- ❖ Эрх бүхий албан тушаалтнуудын зөрчил илрүүлэлт, түүнд авч буй арга хэмжээ нь хууль журмын дагуу явагдаж байгаа эсэх, шалган шийдвэрлэсэн торгуулийн орлогын бүрдүүлэлтэд дотоод хяналт хэрэгжүүлээгүй байгаа тул байгууллагуудын удирдлагуудад дотоод хяналт хэрэгжүүлж, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг хуулийн дагуу явуулах чиглэлээр үүрэг чиглэл өгч ажиллах, Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад хуулийн хүрээнд хяналт хэрэгжүүлэх.

Аймгийн ЗДТГ-ын Санхүү төрийн сангийн хэлтсийн даргын үүргийн түр орлон гүйцэтгэгч Г.Батсайхан, Цагдаагийн газрын дарга, Цагдаагийн хурандаа О.Түмэнбаяр, Онцгой байдлын газрын дарга Г.Нэргүй нарт

- ❖ Аймгийн хүү торгуулийн орлогын дансанд Цагдаагийн газрын тэмдэгтийн хураамж, Улсын бүртгэлийн тэмдэгтийн хураамжийн дансанд Онцгой

байдлын газрын торгуулийн орлого төвлөрүүлснийг залруулаагүй байгаа тул цаашид орлогыг нэр, төрөл бүрээр хяналт хэрэгжүүлэх, үнэн зөв тайлагнах.

Аймгийн ЗДТГ-ын Санхүү төрийн сангийн хэлтсийн даргын үүргийн түр орлон гүйцэтгэгч Г.Батсайханд

- ❖ Торгууль, шийтгэврийн хуудасны тооцоог эрх бүхий албан тушаалтнуудтай хийж, баталгаажуулах.

Ховд аймгийн Цагдаагийн газрын дарга, Цагдаагийн хурандаа О.Түмэнбаярт

- ❖ Торгуулийн орлогын дансанд төвлөрүүлсэн орлогын тулгалтыг нэг бүрчлэн хийх.

Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Шинээрцогт

- ❖ ГХБХБГ нь Орон сууцны 0 болон 1 давхрыг үйлчилгээний зориулалтаар зөвшөөрөлгүйгээр өөрчилж, орон сууцны хана нураах, хаалга гаргах, гадна хийцийг өөрчлөх, статистик мэдээг графикт хугацаанаас хоцроож ирүүлсэн, худал мэдээлсэн тохиолдолд зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж, зөрчлийг таслан зогсоох, чиг үүргээ хэрэгжүүлэх.

Статистикийн хэлтсийн дарга Л.Ариунаад

- ❖ Хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчилд хуулийн дагуу чиг үүргээ хэрэгжүүлэх, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулах.

Байгаль орчны газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Нэргүйд

- ❖ Байгаль орчны салбарын зөрчлийн хэргийн нэгдсэн бүртгэл хөтлөх, улсын байцаагчдын зөрчлийн хэргийн иж бүрдлийг бүрэн хангаж ажиллах



“Хүү, торгоулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт”-д хийсэн аудитын хураангуй тайлан

Алдаа зөрчлийн нэгтгэл:

№	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Үүнээс		Зөвлөмж	
				Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	ХХАА-н газрын ЭБАТ-ууд шалган шийдвэрлэсэн 3 хуулийн этгээдийн зөрчилд оногдуулсан хугацаандаа төлөгдөөгүй 4.5 сая төгрөгийн торгуулийг нэмэгдүүлэн тооцоогүй, албадан төлүүлээгүй	1	4,500,000			1	4,500,000		
2	Замын цагдаагийн хүү торгуулийн орлого, цагдаагийн газрын хүү торгуулийн орлогыг дууу төвлөрүүлсэн, хяналт хэрэгжүүлдэггүй		258,293,400				258,293,400		
3	Оногдуулсан торгуулиас 2023 онд 33 иргэн, 1 аж ахуйн нэгж байгууллагатай холбоотой 22,550.0 мянган төгрөг, 2024 онд 81 иргэнтэй холбоотой 45,400.0 мянган төгрөгийн торгуулийн үлдэгдэлийг төвлөрүүлээгүй /Цагдаагийн газар/	1	67,950,000			1	67,950,000		
4	Хугацаандаа төлөгдөөгүй торгуульд 2024 оны 4 дугаар сараас хойш ЗТХ-н 3.5 дугаар зүйлийн 4-д заасны дагуу нэмэгдүүлэн тооцоогүй, албадан төлүүлээгүй /Цагдаагийн газар/	1	16,100,000			1	16,100,000		
5	Хүүхэд гэр бүл хөгжил хамгааллын газрын 2023, 2024 оны торгуулийн орлогыг төсөвт төвлөрүүлээгүй		8,300,000				8,300,000		
6	Хугацаандаа төлөгдөөгүй торгуульд 2024 оны 4 дугаар сараас хойш ЗТХ-н 3.5 дугаар зүйлийн 4-д заасны дагуу нэмэгдүүлэн тооцоогүй, албадан төлүүлээгүй /ХГБХХГ/	1	550,000			1	550,000		
7	ГХБХБГ-аас барилга эхлэх зөвшөөрөл авалгүйгээр барилгын ажил явуулах, газрын ерөнхий болон хэсэчилсэн төлөвлөгөө зөрчиж барилга байгууламж барьсан зөрчил аймгийн хэмжээнд гарсаар байгаа ч аймгийн ГХБХБГ-аас зөрчлийн хэрэг нээн шалган шийдвэрлээгүй, хяналт хэрэгжүүлээгүй байна.	1	-			1	-		
8	Байгаль орчны газар нь "МоЕнКо" ХХК нь 3.0 сая төгрөгийн торгуулийг төсөвт төвлөрүүлээгүй, 1.5 сая төгрөгийн торгох шийтгэлийг нэмэгдүүлээгүй, "Алтайн зам" ХХК нь 3.0 сая төгрөгийн торгуулийг төсөвт төвлөрүүлээгүй, 1.5 сая төгрөгийн торгох шийтгэлийг нэмэгдүүлээгүй, иргэн Г.Ууганцогт нь 0.1 сая төгрөгийн торгуулийг төсөвт төвлөрүүлээгүй	5	9,100,000			5	9,100,000		
9	Орон сууцны 0 болон 1 давхрыг үйлчилгээний зориулалтаар өөрчилж, орон сууцны хана нураах, хаалга гаргах, гадна хийцийг өөрчлөх зэрэг зөрчлүүдэд аймгийн төвд нийтлэг гарч байхад ГХБХБГ-аас зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулаагүй	1	-				-		1
10	Статистикийн хэлтэс нь 2023, 2024 оны статистик мэдээг график хугацаанаас хоцроож ирүүлсэн 21 зөрчилд зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулаагүй	1	-				-		1
11	Аймгийн хүү торгуулийн орлогын дансанд Цагдаагийн газрын тэмдэгтийн хураамж 922.5 мянга, Улсын бүртгэлийн тэмдэгтийн хураамжийн дансанд Онцгой байдлын газрын торгуулийн орлого 600.0 мянган төгрөг төлснийг ХГБХБГ-аас зарцуулаагүй	1	1,522,500						1,522,500
12	Хөдөлмөрийн эрүүл ахуйн улсын байцаагч 2023 онд Амин зол очир ХХК-д зөрчлийн тухай хуулийн дагуу 1,500.0 мянган төгрөгийн торгууль оногдуулсан ч төсөвт төвлөрүүлээгүй	1	1,500,000			1	1,500,000		1
13	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар 2024 онд 1 зөрчилтэй холбоотой 500.0 мянган төгрөгийн торгуулийн орлогыг төсөвт төвлөрүүлээгүй үлдэгдлийг төлүүлэхээр шүүхэд хандаагүй байна.	1	500,000			1	500,000		
14	Байгаль орчны салбарын торгуулийн нэгдсэн бүртгэл байхгүй, Зөрчлийн хувийн хэргийн иж бүрдэл хангалтгүй.	1	-				-		1
15	Аймгийн Цагдаагийн газраас торгуулийн орлогын дансны орлого, зарлагын гүйлгээнд хяналт хэрэгжүүлээгүй	1	9,889,000				9,889,000		1
16	Эрх бүхий албан тушаалтнуудын зөрчил илрүүлэлт, түүнд авч буй арга хэмжээ нь хууль журмын дагуу явагдаж байгаа эсэх, шалган шийдвэрлэсэн торгуулийн орлогын бүрдүүлэлтэд байгууллагын зүгээс дотоод хяналт хэрэгжүүлээгүй	1	-				-		1
17	Дуут сумын байгаль орчны хяналтын улсын байцаагч 2023 онд 1 зөрчлийн 0.1 сая төгрөг, 2024 онд 1 зөрчлийн 0.3 сая төгрөгийг шалган шийдвэрлэхдээ прокурорт бүртгүүлээгүй	2	400,000			2	400,000		
18	Аймгийн санхүү төрийн сангийн хэлтэс, харьяа дээд байгууллагатай 2024 оны шийтгэлийн хуудасны тооцоог баталгаажуулаагүй	1	-				-		1
Нийт дүн		21	378,604,900		-	14	377,082,400		7 1,522,500